

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ, ҮЙЛДВЭР
БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ
ХӨГЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ**

2019 оны 05-р сарын 27 өдөр

Гурвантэс сум

Энэхүү гэрээг нэг талаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Засаг дарга О.Баттогтох /цаашид Орон нутгийн захиргаа гэх гэх/,

Нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Өмнийн говийн баялаг” ХХК , түүнийг төлөөлж захирал Т.Сонинхүү / цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигч гэх/, нар / цаашид хамтад нь талууд гэх/ харилцан тохиролцож дараах нөхцөлөөр 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Өмнөговь аймгийн Гурвантэс сумын төвд байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээ нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Урт багийн нутагт орших “Өмнийн говийн баялаг” ХХК-ны MV-021252 тоот тусгай зөвшөөрөлтэй Гүн өнгөт чулууны уурхайн байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар аймаг, сумын захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Талуудын хамтын ажиллагааны зорилго нь: уурхайн үйл ажиллагаанаас бий болох хөгжлийн боломжуудыг орон нутгийн иргэдэд тэгш шударгаар хүртээх, нөлөөлөлд өртөх иргэдийн нийгэм, эдийн засаг, соёлын эрх түүний дотор эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хөндөхгүй, дордуулахгүй байхад хуулийн хүрээнд талууд үүрэг хариуцлага хүлээх, уурхайн бизнесийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд тогтвортой эрхлэх нөхцлийг хангахад чиглэнэ.

1.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр материаллаг болон материаллаг бус байдлаар дэмжлэг үзүүлнэ.

1.4. Талууд нь гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо / цаашид хороо гэх/ -г байгуулан ажиллуулна.

Хоёр: Нэр томъёоны тодорхойлолт

Гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог хуульд өөрөөр заагаагүй бол дор дурдсан утгаар ойлгоно.

2.1. “Төсөл” гэж хууль тогтоомжийн дагуу олгогдсон “Өмнийн говийн баялаг” ХХК-өнгөт чулууны уурхайг ашиглахтай холбоотой үйл ажиллагаа, бүтээн байгуулалтыг;

2.2. “Дэд бүтэц” гэж зам, гүүр, талбай, суваг, хоолой, эрчим хүчний эх үүсвэр, ЦДАШ, холбоо харилцаа, ус, дулаан хангамжийн шугам, уурхайн кемп, ажлын байр, үйлдвэрийн зориулалт бүхий барилга байгууламжийг;

2.3. “Орон нутгийн захиргаа” гэж тухайн сумын Засаг дарга болон Нутгийн өөрөө удирдах байгууллагыг

2.4. “Орон нутаг” гэж тухайн сумын нутаг дэвсгэрийг;

2.5. “Нөлөөллийн сум” гэж төслийн үйл ажиллагаа шууд нөлөөлж буй Гурвантэс сумыг;

2.6. “Хөтөлбөр” гэж Өмнөговь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Бид хамтдаа” хөтөлбөр, түүний хүрээнд хэрэгжүүлэх дэд хөтөлбөрүүд, Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлийг;

2.7. “Орон нутгийн аж ахуйн нэгж” гэж Өмнөговь аймгийн татварын газарт бүртгэлтэй аж ахуйн нэгжийг

2.8. “Хамтын ажиллагааны хороо” гэж энэхүү гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий 3 талт ажлын хэсэг /нутгийн захиргаа, компани, БИНХ-аас сонгогдсон иргэдийн төлөөллийг

2.9. “Тогвортой хөгжил” гэдэг нь талуудын нийгэм, эдийн засаг, байгаль орчны асуудлыг цогцоор авч үзсэн дэлхий нийтийн үзэл баримтлал гэж тус тус ойлгон хэрэглэнэ.

Гурав: Хамтын ажиллагаанд талуудын баримтлах зарчмууд

3.1. Талууд харилцан ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрч, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид шударга, тэгш эрхийн зарчмыг хангаж баримтална. Орон нутгийн тогтвортой хөгжил, иргэдийн нийгэм, эдийн засаг, соёлын хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор үр дүнтэй, ил тод, харилцан ач холбогдол бүхий урт хугацааны хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

3.2. Өмнөговь аймаг болон Гурвантэс сумын тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор талууд хүлээсэн үүргээ биелүүлэх, түүнд хяналт тавих, тулгамдаж байгаа асуудалд нэн тэргүүнд анхаарал хандуулж, шаардлагатай зүйлсийн талаар нэгдсэн ойлголтыг бий болгон хамтран ажиллана.

3.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орон нутгийн иргэдийн өмнө хүлээсэн үүргийг тодорхой болгох, уурхайн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, компанийн дэмжлэг нь орон нутагт ашиг тус өгөх явдлыг хангана.

3.4. Талууд ОУИТБС-ын шаардлага, Ашигт малтмалын тухай хуулийн 48.10 дахь заалт, ЗГ-ын 2012 оны 222-р тогтоол, Хамтын ажиллагааны энэхүү гэрээний хэрэгжилтийн тайлан мэдээг жил бүрийн 1-р улирлад багтаан нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх олон талт хэлэлцүүлэг арга хэмжээг зохион байгуулж, сумын Уул уурхайн мэдээллийн төвд тайланг хэвлэмэл байдлаар,цахим сайт, ГУРВАНТЭС СУМ: ЗДТГ-ын ФБ хуудсанд онлайн байдлаар тогтмол байрлуулан сурталчилгаа хийж, аль болох олон талуудын оролцоог хангах замаар хариуцлагатай уул уурхайг төлөвшүлэхийн төлөө ажиллана.

3.5. Энэхүү Хамтын ажиллагааны гэрээ байгуулахын өмнө гэрээний төсөлд, гэрээг сунгах, нэмэлт өөрчлөлт оруулахад түүний заалт бүрийн төсөлд Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагааг явуулна.

Дөрөв: Хамтын ажиллагааны хороо

4.1. Хамтын ажиллагааны хороонд Гурвантэс сумын Засаг даргын томилсон гишүүд нь: Захиргааны байгууллагыг төлөөлөх, Гурвантэс сумын иргэд, ИНБ, Баясах багийн ИНХ-аас сонгогдсон иргэд нь иргэдийг төлөөлөх, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн томилсон албан тушаалтан нь компанийг тус тус төлөөлөн оролцоно.

4.2. Талуудын тэгш оролцоог хангаж, захиргааны байгууллагыг төлөөлж 3, сумын иргэдийг төлөөлж 3, тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж 3, нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулна.

4.3. Хороо нь гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээг хэрэгжүүлэх талаар талуудын гаргасан санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх эрхтэй бөгөөд ажиллах журмыг энэхүү гэрээний хавсралт 1-д заасны дагуу талууд тодорхойлно.

Тав: Талуудын нийтлэг эрх, үүрэг

5.1. Засаг даргын эрх, үүрэг

5.1. Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

5.1.1. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал ашиглах, тээвэрлэх үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах;

5.1.2. Засаг дарга нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ аль болох ОУИТБС-ын сумын дэд зөвлөл, гэрээний Хамтын ажиллагааны хороотой хамтран ажиллах зарчим баримтлах

5.1.3. Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар ОУИТБС-ын сумын дэд зөвлөлтэй хамтран орон

нутгийн иргэдэд Уул уурхайн мэдээллийн төвөөр дамжуулан тогтмол мэдээлэл өгч, санал, хүсэлтийг авах;

5.1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах;

5.1.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх.

5.1.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн санхүүгийн дэмжлэг хөтөлбөрийн дагуу зарцуулагдаж байгаа эсэхэд хяналт тавих талуудын оролцоог хангана.

5.1.7. Санхүүжүүлэх хөтөлбөрт орон нутгийн иргэдтэй зөвлөлдөж тэдгээрийн саналыг тусгасан байна.

5.1.8. Энэхүү гэрээний хэрэгжилтийн талаар тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих хяналтыг Хамтын ажиллагааны хороотой хамтран хэрэгжүүлнэ.

5.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

5.2. Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

5.2.1. Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх;

5.2.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ аль болох ОУИТБС-ын сумын дэд зөвлөл, гэрээний Хамтын ажиллагааны хороотой хамтран ажиллах зарчим баримтлах бөгөөд Уул уурхайн мэдээллийн төвийг олон нийтэд мэдээлэл хүргэх, эргэх холбоо тогтоох тогтвортой механизм болгоход дэмжлэг үзүүлж бэхжүүлэх зарчим баримтлаж ажиллана.

5.2.3. Компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн дэд бүтэц хөгжүүлэх үйл ажиллагаа болон соёл, боловсрол бүтээн байгуулалтын ажилд хандив туслалцаа үзүүлэх зорилгоор гэрээний хүчин төгөлдөр хугацаанд нийт 30000000 / гучин сая / хүртэл төгрөгийн хөрөнгө оруулалтыг орон нутагт оруулж хамтран ажиллана.

5.2.4. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон төлөвлөгөөний дагуу үйлдвэр, уурхайн орчин, замын маршрутын дагуу хөрс, ургамал, булаг, шанд гол, горхи, ан амьтан хамгаалах ажлыг зохион байгуулж холбогдох нөхөн сэргээлтийг хийнэ.

5.2.3. Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;

5.2.4. Орон нутгийн хөгжил, иргэдийн боловсрол, эрүүл мэнд, түүх соёл, аялал жуулчлал, уламжлалт мал аж ахуйн салбарын чиглэлийн үйл ажиллагааг дэмжинэ. Энэхүү гэрээгээр хязгаарлагдахгүй нийгмийн хариуцлагын хүрээнд тухайн орон нутгийн иргэд, аж ахуй нэгж байгууллага, Төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.

5.2.5. Олборлох үйлдвэрийн ил тод байдлын тайлан болон төслийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг орон нутгийн захиргааны байгууллага, олон нийтэд хагас, бүтэн жилээр мэдээлнэ.

5.2.6. Үйлдвэрлэлийн шаардлагатай дэд бүтэц, барилга байгууламж барихад, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, хүний нөөцийг бэлтгэнэ.

5.2.7. Орон нутгийн иргэд, байгууллагын өвлийн хэрэгцээний нүүрсний хэмжээ, хөнгөлөлттэйгөөр нийлүүлэх асуудлыг аймгийн удирдлагатай зөвшилцөн шийдвэрлэнэ.

5.2.8. Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах;

5.2.10. Өөр орон нутгаас ажилтан, мэргэжилтэн урт хугацаагаар авч ажиллуулах тохиолдолд холбогдох хуулийн дагуу ажилтануудыг сумын Засаг даргын Тамгын газарт бүртгүүлэх;

5.2.11. Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар сумын иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч байх;

5.2.12. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох;

5.2.13. Гэрээний үүргээ биелүүлэхэд шаардлагатай мэдээ тайланг Засаг дарга болон холбогдох мэргэжилтэн-ээс шаардах.

5.2.14. Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх.

Зургаа: Компанийн гүйцэтгэх ажил

6.1. Байгаль орчныг хамгаалах талуудын эрх, үүрэг:

6.1.2. "Нэг тонн баялаг-Нэг мод" хөтөлбөрийн хүрээнд эвдэрсэн газар нөхөн сэргээх, ногоон байгууламж байгуулах.

6.1.3. Орчны хяналт шинжилгээний ажлыг нутгийн иргэд, холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулах, үр дүнг тайлагнах

6.1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тоосжилт, орчны бохирдлоос сэргийлэх арга хэмжээ тогтмол авч хэрэгжүүлнэ.

6.1.5. Байгаль хамгаалах тэмдэглэлт өдрүүдэд оролцох, Байгаль орчны холбогдох мэдээ мэдээллийг олон нийтэд сурталчилах ажилд орон нутгийн байгаль орчны мэрэгжтнүүдтэй хамтран ажиллана.

6.2. Орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр хүлээх үүрэг:

6.2.1. Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хүнсний бүтээгдэхүүн, бараа, ажил үйлчилгээний 80-иас доошгүй хувийг орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлэх замаар тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

6.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр талуудын хүлээх үүрэг:

6.3.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нийт ажиллагсдын 70-иас /доошгүй хувийг Өмнөговь аймгийн Гурвантэс сумын иргэдийг ажиллуулах үүргийг хүлээнэ.

6.3.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хөдөлмөр эрхлэгч иргэдтэй ажиллах гэрээний хугацаанаас үл хамааран Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу хөдөлмөрийн гэрээ байгуулан, эрүүл мэнд, нийгмийн даатгалд бүрэн хамруулж, Үйлдвэрчний эвлэл байгуулж аймгийн ҮЭ-ийн хороотой нягт хамтран ажиллана.

6.3.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрөө болон туслан гүйцэтгэгч, оператор ХХК-иудын хамт орон нутгийн ажилчдын нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татварыг аймаг, сумын төсвийн дансанд төвлөрүүлж, ажилчдын нийгмийн суурь үйлчилгээг шуурхай авах боломжийг бүрдүүлнэ.

6.3.5. Ажиллах хүчин авахдаа ил тод нээлттэй зарлаж, ажилд авсаны дараа иргэдэд нэрсийг нээлттэй зарлах, тэдгээрийн хариуцлага, албан тушаал дээр гаргаж байгаа ахиц амжилтыг нийтэд мэдээлдэг байна.

6.4. Уул уурхайн ил тод нээлттэй байдлыг хангах, засаглалыг сайжруулах чиглэлээр:

6.4.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нөлөөллийн бүсийн айлуудад мэдээлэл өгдөг, гомдол маргаан, үл ойлголцол таслах, уулзалт арга хэмжээ зохион байгуулах тогтсон өдөртэй болж, сар бүрийн сүүлийн долоо хоногийн бямба гарагт зохион байгуулах;

6.4.2. Талууд уул уурхайн салбарын болон энэхүү төсөлтэй холбоотой асуудлаар олон нийтийн уулзалт, хэлэлцүүлэг, арга хэмжээ зохион байгуулахдаа ОҮИТБС-ын дэд зөвлөлтэй хамтран зохион байгуулах бөгөөд хэлэлцэх асуудал түүний хөтөлбөрийг ажлын 7-10 хоногийн өмнө зарлаж нийтэд хүргэсэн байх үүрэг хүлээнэ.

6.4.3. Талууд уул уурхайн төслийн үйл ажиллагаанд сумын иргэн, ААН-ээс нийлүүлж, худалдан авч болох бараа, үйлчилгээг жил бүрийн эхэнд санал болгож, танилцуулах уулзалтыг 2 талаасаа нээлттэй зохион байгуулж мэдээллийг Уул уурхайн мэдээллийн төвд байршуулах;

Долоо. Гэрээний хэрэгжилт

7.1. Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймаг, сумын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлөөр дамжуулан ОҮИТБС-ын ажлын албанд хүргүүлнэ.

7.2. Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

7.3. Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор дээд шатны Засаг дарга болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

7.4. Энэхүү гэрээний заалтын дагуу жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх бөгөөд тайланг ИТХ -д танилцуулна.

7.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрөл дуусгавар болсон эсхүл цуцлагдсан тохиолдолд хугацаанаас өмнө гэрээг цуцалсанд тооцно.

7.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь төсөл дуусгавар болохоос өмнө гурваас доошгүй жилийн өмнө төслийн хаалтын төлөвлөгөөг боловсруулж талуудад танилцуулж түүнд оролцох орон нутгийн иргэдийн оролцоог бүрдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Найм. Гэрээний хариуцлага

8.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

8.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад

тогтоосон хугацаанд хүргүүлснээр дараа жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан батлахад харгалзан үзэх үндэслэл болно.

Ес. Маргаан шийдвэрлэх

9.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо Захиргааны шүүхэд гаргаж болно.

Арав. Гэрээ хүчин төгөлдөр болох

10.1. Талууд гарын үсэг зурсан өдрөөс гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

10.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

10.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

10.4. Гэрээг монгол хэл дээр гурван хувь үйлдэнэ. Зайлшгүй тохиолдолд гэрээний хувийг англи хэл дээр үйлдэж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ОРОН НУТГИЙН ЗАХИРГААГ ТӨЛӨӨЛЖ

Гурвантэс сумын Засаг Даргын
Тамгын газрын дарга

..... О.БАТТОГТОХ
Өмнөговь аймаг Гурвантэс сум

утас: 99052115

цахим шуудан:

КГ А 0001

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ

Өмнөговь
АЙМАГ
Ерөнхий Захирал

..... Т.СОНИНХҮҮ
Өмнөговь аймаг Гурвантэс сум

утас: 89220076

цахим шуудан:

---oOo---